



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

“Тэгш” ХК-ийн нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ биелүүлэхээр бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Тэгш” ХК-ийн нийт гаргасан 156,857 ширхэг хувьцааны 98,07 хувь буюу 153,835 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Дониддавга овогтой Ганбат, Ганбат овогтой Мөнх-Эрдэнэ, “Элеганттаун” ХХК-иудаас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 1,93 хувь буюу 3022 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 2987 /хоёр мянга есөн зуун наян долоо/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Тэгш” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Д.Ганбат/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-г заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;


2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

000203

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА-2 Д.БАЯРСАЙХАН

A red square stamp is located in the center of the page. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН УЛСЫН ШУЛГАН" (Mongolian State Court) arranged around a central emblem featuring a flame and a sun. A black ink signature is written across the stamp, starting from the left and ending with an arrow pointing towards the right.